

# InvesCore FI

## “ИНВЕСКОР ББСБ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ШИЙДВЭР

2026 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр

№ А/01

Улаанбаатар хот

*Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн  
тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн  
дүгнэлтийг хэлэлцэн батлах тухай*

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалт, “Инвескор ББСБ” ХК (цаашид “Компани” гэх)-ийн Дүрмийн 8 дугаар зүйлийн 8.5.9 дэх заалт, Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын шийдвэрийг тус тус үндэслэн **ШИЙДВЭРЛЭХ нь:**

1. Компанийн 2025 оны үйл ажиллагааны тайлан болон “Эрнст энд Янг Монголия Аудит” ХХК-иар баталгаажуулсан санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг баталсугай.
2. Энэхүү шийдвэрийг Монгол Улсын Компанийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид заасан хугацаанд зохих журмын дагуу мэдээлж, эрх бүхий байгууллагуудад хүргүүлэхийг Төлөөлөн удирдах зөвлөлийн Нарийн бичгийн дарга /Б.Буд/-д даалгасугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ДАРГА



# InvesCore FI

## “ИНВЕСКОР ББСБ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ШИЙДВЭР

2026 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр

№ А/02

Улаанбаатар хот

*Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны төсөв батлах тухай*

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.13 дах заалт, “Инвескор ББСБ” ХК (цаашид “Компани” гэх)-ийн Дүрмийн 8 дугаар зүйлийн 8.5.12 дахь заалт болон Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын шийдвэрийг тус тус үндэслэн **ШИЙДВЭРЛЭХ нь:**

1. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны үйл ажиллагааны төсвийг шийдвэрийн Нэгдүгээр хавсралтаар баталсугай.
2. Энэхүү шийдвэрийг Монгол Улсын Компанийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид заасан хугацаанд зохих журмын дагуу мэдээлж, эрх бүхий байгууллагуудад хүргүүлэхийг Төлөөлөн удирдах зөвлөлийн Нарийн бичгийн дарга /Б.Буд/-д даалгасугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ДАРГА



# InvesCore FI

"Инвекор ББСБ" ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн  
ээлжит хурлын 2026 оны 04 дүгээр сарын 29-ний  
өдрийн А/02 тоот шийдвэрийн Хавсралт 01



## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН 2026 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨСӨВ

| Зардлын төрөл              | Давтамж | Дүн /төг/  | Нийт дүн /төг/ |
|----------------------------|---------|------------|----------------|
| ТУЗ-ийн гишүүдийн цалин    | 12 удаа | 29,976,458 | 359,717,500    |
| ТУЗ-ийн ажлын албаны цалин | 12 удаа | 2,500,000  | 30,000,000     |
| ТУЗ албан томилолт         | 1 удаа  | 45,000,000 | 45,000,000     |
| ТУЗ-ийн хурлын зардал      | 4 удаа  | 250,000    | 1,000,000      |
| ТУЗ-ийн гишүүдийн сургалт  | 1 удаа  | 5,000,000  | 5,000,000      |
| Бусад зардал               | -       | 5,600,000  | 5,600,000      |
| Нийт дүн                   |         |            | 434,717,500    |

\*2027 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийг  
дуустал 12 сарын нэгтгэсэн дүнгээр

\_\_oOo\_\_

# InvesCore FI

## “ИНВЕСКОР ББСБ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ШИЙДВЭР

2026 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр

№ А/03

Улаанбаатар хот

*Компанийн хувьцаа хуваах шийдвэрийг шинэчлэн батлах  
Компанийн дүрмийн нэмэлт өөрчлөлт батлах*

Компанийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх заалт, 62 дугаар зүйлийн 62.1.1, 62.1.6 дахь заалт, “Инвескор ББСБ” ХК (цаашид “Компани” гэх)-ийн Дүрмийн 8 дугаар зүйлийн 8.5.6 болон Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын шийдвэрийг тус тус үндэслэн **ШИЙДВЭРЛЭХ нь:**

1. Компанийн нэг бүр нь 227 төгрөгийн нэрлэсэн үнэтэй, нийт 82,000,000 ширхэг зарласан энгийн хувьцаа, 75,744,281 ширхэг гаргасан энгийн хувьцаа бүрийг 10-т хувааж, нэг бүр нь 22.7 төгрөгийн нэрлэсэн үнэтэй, 820,000,000 ширхэг зарласан энгийн хувьцаа, 757,442,810 ширхэг гаргасан энгийн хувьцаа болгон хуваасугай.
2. Компанийн хувьцааг хуваах зорилго, үндэслэл, хувьцаа хуваах ажлыг гүйцэтгэх журмыг тусгасан “Хувьцаа хуваах төсөл”-ийг шийдвэрийн Нэгдүгээр хавсралтаар баталсугай.
3. Компанийн хувьцааг хуваасантай холбоотой өөрчлөлтийг тусгасан Компанийн дүрмийн нэмэлт өөрчлөлтийн төслийг шийдвэрийн Хоёрдугаар хавсралтаар баталсугай.
4. Энэхүү шийдвэрт заасны дагуу үнэт цаасны бүртгэлд орсон өөрчлөлтийг холбогдох эрх бүхий байгууллагуудад бүртгүүлэх, зөвшөөрөл олгосон тохиолдолд Компанийн дүрмийн нэмэлт өөрчлөлтийг хууль тогтоомжид заасан хугацаанд Санхүүгийн зохицуулах хороо болон Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газарт хүргүүлэх, зохих бүртгэлийг хийлгэх ажлыг зохион байгуулахыг Гүйцэтгэх захирал /Д.Оролмаа/-д даалгасугай.
5. Компанийн хувьцаа хуваах шийдвэрийг шинэчлэн баталсантай холбогдуулан Компанийн 2022 оны 09 дүгээр сарын 07-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын А/05 дугаар “Компанийн хувьцаа хуваах төслийг батлах тухай” шийдвэр болон 2023 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын А/03 дугаар “Компанийн хувьцаа хуваах шийдвэрт өөрчлөлт оруулах тухай” шийдвэрүүдийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

# InvesCore FI

6. Энэхүү шийдвэрийг Монгол Улсын Компанийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид заасан хугацаанд зохих журмын дагуу мэдээлж, эрх бүхий байгууллагуудад хүргүүлэхийг Төлөөлөн удирдах зөвлөлийн Нарийн бичгийн дарга /Б.Буд/-д даалгасугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ДАРГА

